



## МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

**Дугаар: 2011/08**

**Огноо: 2011 оны 8 дугаар сарын 24**

**Эмбарго: 2011 оны 8-р сарын 25-ний Пүрэв гаригийн 11:00 цаг хүртэл**

Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2011 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн хурлаас бодлогын хүүг 0.25 нэгж хувиар нэмэгдүүлж 11.75 хувьд хүргэх, Заавал байлгах нөөцийн хувийг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 11 хувь болгох шийдвэр гаргалаа.

Үндэсний Статистикийн Хорооны 2011 оны 7 дугаар сарын мэдээгээр хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляци улсын хэмжээнд жилийн 10.1 хувь, Улаанбаатар хотынх жилийн 11.4 хувьд тус тус хүрлээ.

Хүний хөгжил сангаас олгож буй бэлэн мөнгө, төсвийн өндөр зарлага, хувийн хэвшлийн эрэлт өссөн нь нийт эрэлтийг нэмэгдүүлсэн, мөн төрийн зохицуулалттай зарим барааны үнэ өссөнөөс суурь инфляци сүүлийн 5 сарын турш тасралтгүй өсч 12 хувьд хүрлээ. Энэ ондоо нийт эрэлтийн инфляцид үзүүлэх нөлөө буурахааргүй байна. Сүүлийн саруудад шатахууны үнэ өссөнөөс тээврийн үйлчилгээний үнэ нэмэгдсэн. Нийлүүлэлтийн талын энэ хүчин зүйлийн нөлөөгөөр тээврийн зардлаар дамжин бусад бараа, үйлчилгээний үнэ нэмэгдэх эрсдэлтэй байна.

Иймд Монголбанк инфляцийн хүлээгдэж буй дарамтыг бууруулах, эдийн засгийн халалтыг сааруулах, санхүүгийн салбарын найдвартай байдлыг улам бэхжүүлэх зорилгоор дээрх арга хэмжээг авч байна.

**МОНГОЛБАНК**